



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 4126

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн тавдугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (О.Энхболд)-т даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
04 сарын 15 - ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Баянгол дүүрэг, Илаарших өрхийн эрүүл мэндийн төв	68/2025	1 жил	2025.03.19	2026.03.19
2.	Баянгол дүүрэг, Эрхэмжаргалан өрхийн эрүүл мэндийн төв	69/2025	3 жил	2025.04.12	2028.04.12
3.	Налайх дүүрэг, Амь-Эрдэнэ өрхийн эрүүл мэндийн төв	70/2025	2 жил	2025.04.18	2027.04.18
4.	Улаанбаатар хот, Хос шинэс ХХК-ийн сувилал	71/2025	3 жил	2025.03.24	2028.03.24
5.	Булган аймаг, Аймгийн нэгдсэн эмнэлэг	72/2025	2 жил	2025.03.29	2027.03.29
6.	Булган аймаг, Бугат сумын эрүүл мэндийн төв	73/2025	2 жил	2025.04.18	2027.04.18
7.	Булган аймаг, Гурванбулаг сумын эрүүл мэндийн төв	74/2025	2 жил	2025.04.18	2027.04.18
8.	Булган аймаг, Хялганат тосгоны эрүүл мэндийн төв	75/2025	2 жил	2025.04.18	2027.04.18
9.	Төв аймаг, Зүмбэрэлсүмбэр ХХК-ийн эмнэлэг	76/2025	2 жил	2025.04.10	2027.04.10
10.	Ховд аймаг, Мөнхцохилохуй эмнэлэг	77/2025	2 жил	2025.04.01	2027.04.01
11.	Ховд аймаг, Рашаант өрхийн эрүүл мэндийн төв	78/2025	2 жил	2025.04.01	2027.04.01
12.	Дархан-Уул аймаг Батцагаанбуянт ХХК-ийн Буянтай эмнэлэг	79/2025	1 жил	2025.03.13	2026.03.13